

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо** : 2019 оны 09 дүгээр сарын 30 ны өдөр

**Тендер шалгаруулалтын нэр**: Хороодын дундах чулуун зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 12, 13 дугаар хороо/ ажил

**Тендер шалгаруулалтын дугаар**: ЧДХААА А19/017

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Хороодын дундах чулуун зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 12, 13 дугаар хороо/ -“ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.**

Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо**: Сүүлийн 2 жил /2017, 2018/-ийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
- 2. Борлуулалтын хэмжээ**: Сүүлийн 3 жил /2016, 2017, 2018 он/-ийн дундаж нь 427 000 000 /дөрвөн зуун хорин долоон сая/ төгрөгөөс багагүй байна.
- 3. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүн**: 183 000 000 /нэг зуун наян гурван сая/ төгрөгөөс төгрөгөөс багагүй байна.
- 4. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо**: Сүүлийн 3 жил / 2016, 2017, 2018/ он.
- 5. Тендерийн баталгаа**: 6 100 000 /зургаан сая нэг зуун мянга/ төгрөг.
- 6. Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: “Туйм”**  
Зам тээврийн яамнаас олгосон: 2.8.1. Хатуу хучилттай автозам барих заалт бүхий тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбар, гэрээг тус тус **нотариатаар** баталгаажуулж ирүүлнэ.

**Эсхүл**: Зам тээврийн сайдын 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 152 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ын 3.7.1.1. ЗБ-1 Хатуу хучилттай зам барих заалтанд хамаарах төрлийн тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбар, гэрээг тус тус **нотариатаар** баталгаажуулж ирүүлнэ.

**Эрчим хүчний яамнаас олгодог**: 03.2.1 Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар 0.4-10кВ ба болон түүнээс дээш заалт бүхий тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбар, гэрээг тус тус **нотариатаар** баталгаажуулж ирүүлнэ.

Тендерийг **2019 оны 10 дугаар сарын 31 өдрийн 10 цаг 00** минутаас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны албаны 5 дугаар давхар, 511 тоот өрөөнд **2019 оны 10 дугаар сарын 31 өдрийн 10 цаг 15** минутад нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.  
Дотоодын давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн  
Нутгийн захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын байр Худалдан авах ажиллагааны алба, 5 дугаар давхар,  
511 тоот өрөө, Утас : 70110769*